

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2023 оны 7 сарын 07 өдөр

№ R-2023-64

Улаанбаатар хот

Холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй
этгээдтэй хийсэн хэлцлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") -ийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн R-2022-62 дугаар тогтоол болон ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд, гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ")-ны хурлаар хэлэлцээд, энэхүү тогтоолын хавсралтад заасан холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн 12 (арван хоёр) хэлцэл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-ийг батлах зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй нөхцөлөөс илүү давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
3. ТУЗ нь ЭУХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ